БАТЛАВ.

ХЯРГАС НУУР - ЗАВХАН ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Э.ЗОЛ-ОД

БАТЛАВ.

ФОРС ГОЛД МАЙНИНГ ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНБААТАР

# УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 06 сарын
12-ны өдөр | Дугаар 04 | Завхан аймаг, Улиастай сум

## Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д заасны дагуу Усны газрын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Е-2404-000007 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, "Тэсийн бүрд" ХХК-ний 2018 оны шавхалт туршилтын ажлын тайлан, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/15 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

**Ус ашиглуулагчийг төлөөлж:** Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн, ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг,
**Ус ашиглагчийг төлөөлж:** Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоотод байрлах Форс Голд Майнинг ХХК (Улсын бүртгэлийн дугаар 9011622079, Регистрийн дугаар 6088759)–ийн ерөнхий геологич Дандар овогтой Содном нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 3 эх үүсвэрийг шавхалт хийж бодит нөхцөл байдлыг тодорхойлж Усны боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглуулах дүгнэлтийг шинэчлэн гаргуулах хүртэлх хугацаатайгаар байгуулав.

## Хоёр. Гэрээний гол нөхцөл

**2.1. Ус ашиглах зориулалт:** Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологи, ногоон байгууламж, зам талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэнд ашиглана. "Тэсийн бүрд" ХХК-н 2018 оны 5 дугаар сарын 12 өдрөөс 14-ний өдрүүдэд хийсэн шавхалтын тайланг үндэслэн хоногт 172.04 $м^3$ ус ашиглахаар 2024 оны усны хэмжээг тооцлоо.

**2.2. Ашиглах усны хэмжээ:**
Нийт усны хэмжээ: 18,923 $м^3$/жил

2.2.1 Технологийн ус 16,462.0 $м^3$
2.2.2 Унд ахуйн хэрэгцээ 644 $м^3$
2.2.3 Зам талбайн тоосжилт дарах 1,699 $м^3$
2.2.4 Тэрбум мод усалгаа 118 $м^3$

| № | Худгийн нэр | X | У | Ундарга л/с |
|---|---|---|---|---|
| 1 | Худаг 1 | 93 58 20.06 | 48 25 52.06 | - |
| 2 | Худаг 2 | 93 58 13.33 | 48 25 50.31 | - |
| 3 | Худаг 3 | 93 58 34.15 | 48 25 54.66 | - |

**2.3. Усны чанар, найрлага**: Уурхайн ашиглалтын худгуудын усны чанарын шинжилгээг улирал бүр хийлгэж, дүнг улирал бүр-Хяргас нуур Завхан голын сав газрын захиргаанд ирүүлэх.

**2.4. Усны эх үүсвэр**

Форс Голд Майнинг ХХК-н өөрийн хөрөнгөөр бий болгосон 3 гүний худгийн 2018 онд хийсэн шавхалт, туршилтын ажлыг үр дүнгээр ашиглах боломжит усны нөөц хүрэлцэхгүй муу бөгөөд 3 цооног нийт 172.04 $м^3$/хоног буюу 172042 литр ус ашиглах боломжтой гэж тогтоосон.

**Байршил:**

- Ургамал сумын Тосгуур багийн Ханын худаг орчим Цагаан толгой ордын гүний усны 3 ширхэг худаг (Худаг 1, 2, 3)

**Барилга байгууламж:** Өрөмдмөл худаг

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 1**
марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 2**
марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 3**
марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

**2.5. Хаягдал ус:**

**Хэмжээ:** Унд ахуйн хэрэгцээнд нормоор тооцоход жилд 644.0 $м^3$ ус хэрэглэж, хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэн ашиглана.

**2.5.1.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

**2.6.** Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

**Технологи** Механик болон биологийн арга
**Цэвэрлэгээний түвшин** Дахин ашиглах цэвэрлэсэн ус MNS

6734:2018 стандартын шаардлагыг хангасан байх

2.6.1. Бохир усыг хөрсөнд нэвчүүлэн ил задгай хаяхгүй байх.

**2.7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:**

2.7.1. Усны боломжит нөөцийн дүгнэлтийг 8 дугаар сарын 30-ны дотор шинэчлэн гаргуулж, ус ашиглах дүгнэлт, гэрээг дахих хийх

2.7.2. Малчдын болон ашиглалтын худаг, усны чанар, гүний усны түвшинд хэмжилт хийж хэмжилтийн үр дүнг хагас, бүтэн жилээр 2 удаа хийж мэдээг ирүүлэх.

2.7.3. Бага оврын цэвэрлэх байгууламжтай болох хаягдал бохир усыг цэвэршүүлж саарал усыг дахин ашиглах.

2.7.4. Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, усны бохирдол, усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллана. /улирал бүр/

2.7.5. Ус ашиглалтын явцыг хянаж, усыг зохистой ашиглана. Ашиглалтын 3 худгуудыг стандартын шаардлага хангасан барилга байгууламжтай болгох

2.7.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 онд 35,7 сая төгрөг тусгасан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийх.

2.7.7. Газар доорхи усны байгалийн горимыг хянах зорилгоор ашиглалтын худгийн ойролцоо мониторингийн цооног гаргах

2.7.8. Ашиглалтын худгаас авч буй усыг бүртгэлжүүлж бүртгэлийн дэвтэрийг хөтөлж, баталгаажуулан ажиллах.

**2.8. Усны тоолуурын :**

| | |
|---|---|
| Төрөл, нэр, дугаар: | **Худаг 1** |
| Тоолуурын дугаар: | 303099587 |
| Загвар: | LXLG-80 |
| Тоолуурын тоо: | 1 |
| Суурилуулсан байгууллага: | "Форс Голд Майнинг" ХХК |
| огноо: | 2024.06.18 |
| Баталгаажуулсан байгууллага: | Стандарт, хэмжил зүйн газар |
| огноо: | 2026.05.27 |
| Тоолуурын заалт: | 007539 $м^3$ (2024 оны 05 дугаар сарын 27-ны байдлаар) |

| | |
|---|---|
| Төрөл, нэр, дугаар: | **Худаг 2** |
| Тоолуурын дугаар: | 202304191 |
| Загвар: | LXLC-80 |
| Тоолуурын тоо: | 1 |
| Суурилуулсан байгууллага: | "Форс Голд Майнинг" ХХК |
| огноо: | 2024.06.18 |

Wondershare PDFelement

Баталгаажуулсан байгууллага: Стандарт, хэмжил зүйн газар
огноо: 2026.05.27
Тоолуурын заалт: 005338 $м^3$
(2024 оны 05 дугаар сарын 27-ны байдлаар)

Төрөл, нэр, дугаар: **Худаг 3**
Тоолуурын дугаар: ................
Загвар: ................
Тоолуурын тоо: 1
Суурилуулсан байгууллага: "Форс Голд Майнинг" ХХК
огноо: ....................
Баталгаажуулсан байгууллага: ....................
огноо: ....................
Тоолуурын заалт: ....................

**2.9.** Ургамал сумын Тосгуур багийн төлөөлөл, байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, "Форс голд майнинг" ХХК-ний холбогдох хүмүүсийг байлцуулан цэвэр усны тоолуурын заалтыг сар тутам авч баталгаажуулан ус ашиглалтын мэдээнд оруулж байх.

**2.10.** Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх, хайс хашлага тэмдэгжүүлэлтийн бүрэн бүтэн байдлыг хангах

**2.11.** Усны боломжит нөөцийн дүгнэлтийг шинэчлэн гаргуулж ус ашиглах дүгнэлт, гэрээг дахин хийх

**2.12. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:**

*2.12.1. Технологийн усны хэрэглээ:*

16,462.0 $м^3$ x 1711.08 төг = 28,167,798

*2.12.2. Тэрбум мод усалгаанд:*

118 $м^3$ x 81.48 төг = 9,614

*2.12.3. Зам талбайн тоосжилт:*

1699 $м^3$ x 162.96 төг = 276,869

**Нийт төлбөр:**

28,167,798 + 9,614 + 276,869 **= 28,454,281 төг**

/усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

Ашиглалтын худгуудаас авч байгаа гүний ус ашигласан төлбөрийг Завхан аймгийн Төрийн сангийн 1165117377 тоот дансанд төвлөрүүлэх

## Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.5, 17.1.9, 17.1.10, 18.1.4, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.
4.5.3. ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
4.5.4. байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;
4.5.5. ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;
4.5.6. усны эх үүсвэрийг бохирдуулсан;
4.5.7. усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;
4.5.8. сав газрын захиргааны шийдвэрээр;

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус ашиглагчийг төлөөлж: |
| --- | --- |
| ........................................ | ........................................ |
| Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг | Форс Голд Майнинг ХХК–ний ерөнхий геологич Дандар овогтой Содном |
| Харилцах утас: 89098282 | Харилцах утас: 88106854 |